



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан, бүртгэх дүрэм”-ийн 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Аж ахуйн нэгж, байгууллагын Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажиллах заавар /аргачилсан зөвлөмж/-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү заавар /аргачилсан зөвлөмж/-ыг байгууллагын Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулах, үйл ажиллагааг нь зохион байгуулахад аргачлал болгон ашиглахыг нийт ажил олгогч нарт зөвлөсүгэй.

САЙД



Н.НОМТОЙБАЯР

**Аж ахуйн нэгж, байгууллагын Үйлдвэрлэлийн осол,  
хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны  
бус байнгын комиссын ажиллах заавар  
/аргачилсан зөвлөмж/**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү зааврын зорилго нь аж ахуйн нэгж, байгууллагын дэргэд Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулж, ажиллуулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын акт үйлдэх, тогтоох, батлуулж хянуулах, комиссын гишүүдийг чадавхижуулах, ажлаа явуулах нөхцөл боломжоор хангах, гишүүдэд урамшуулал олгох, дэмжлэг үзүүлэх, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад аргачилсан зөвлөмж болгоход оршино.

1.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс нь осол, хурц хордлогыг судлан бүртгэх үйл ажиллагааг явуулах, комиссын гишүүдийг сургаж, дадлагажуулах, ажиллах нөхцөл боломжоор хангах ажлыг зохион байгуулахдаа энэхүү зааврыг нэгэн адил арга зүйн чиглэл, зөвлөмж болгоно.

**Хоёр. Комисс байгуулж, ажиллуулах талаар**

2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасны дагуу Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг тухайн байгууллага, ажил олгогчийн шийдвэр /тушаал, захирамж/-ээр байгуулна.

2.2. Комисс нь ажил олгогчийн болон ажилтны төлөөлөл бүхий 3-аас доошгүй гишүүнтэй байна. Тухайн байгууллагын ажилтны тооноос хамаарч бүрэлдэхүүний тоог тогтооно. Комиссын бүрэлдэхүүнд байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, эрүүл ахуйч, эмч, хүний нөөцийн ажилтан зэрэг шаардлагатай ажил мэргэжлийн төлөөллийг оруулна.

2.3. Комисс байгуулсан тухай нийт ажилтнуудад танилцуулж, мэдээлнэ.

2.4. Комиссын дарга, гишүүд өөрчлөгдсөн нөхцөлд нөхөн томилох, комиссыг шинэчлэн байгуулах ажлыг тухай бүр нь хийж байна.

2.5. Комиссын гишүүдэд урамшуулал олгох асуудлыг ажил олгогч шийдвэрлэнэ. Энэ асуудлаар байгууллагын даргын шийдвэр /тушаал, захирамж/ гарсан байна.

**Гурав. Комиссын үйл ажиллагааны чиглэлийн талаар**

3.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан шалтгаан, нөхцөл, цаашид анхаарах, сэрэмжлүүлэх талаар мэдээлэл, сурталчилгаа хийж, урьдчилан сэргийлэх ажлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, нэгж, ажил олгогчтой хамтран зохион байгуулна.

3.2. Ажилтны эрүүл мэндэд аюул эрсдэл учруулах, ажлын байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, орчны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл, нөхцөл байдлыг арилгах талаар ажил олгогч, ажилтнуудад санамж, зөвлөмж өгнө.

3.3. Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ хийхэд энэ комиссын гишүүдээс оролцуулж болно.

3.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэж, акт тогтоосон тухай ажил олгогчид мэдэгдэж, танилцуулна.

3.5. Комисс нь өөрийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар байгууллагын удирдлага, ажил олгогчид санал, хүсэлтээ гаргаж, асуудлаа шийдвэрлүүлнэ.

#### **Дөрөв. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үед комиссын ажиллах чиглэлийн талаар**

4.1. Осолдогчид эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.2. Осол, хурц хордлого гарсан орчныг хамгаалалтанд авч, аюултай нөхцөл байдлыг арилгах ажлыг холбогдох алба, хэлтэс, ажилтанд мэдэгдэж, арга хэмжээ авна.

4.3. Осол, хурц хордлого гарахад хамт байсан болон гэрч хүмүүсийг судлан тогтооно. Гэрчүүдтэй уулзаж тайлбар, ярилцлага хийж, тэмдэглэл хөтлөнө.

4.4. Осол, хурц хордлого гарах үеийн нөхцөл байдлын талаар фото зураг авч, бичлэг хийнэ.

4.5. Осол, хурц хордлого гарсан үед комиссын үйл ажиллагаанд шаардлагатай бичиж, тэмдэглэх хэрэгсэл, зургийн аппарат, дуу хураагч, метр, гар чийдэн, асгарсан шингэн зүйлийн дээж авах сав /шүлтлэг болон химийн шингэний/ зэрэг зүйлийг байнга бэлэн байлгана.

#### **Тав. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд анхаарах асуудлын талаар**

5.1. Буруутанг эрж хайхдаа гол нь биш, осол, хурц хордлогын шалтгааныг зөв олж тогтооход комиссын ажил чиглэнэ.

5.2. Осол, хурц хордлогыг судлан бүртгэхийн өмнө комисс хуралдаж, комиссын гишүүд болон комисст оролцон ажиллаж байгаа хүмүүст ажлын чиглэл өгч, мэдээлэл, баримт цуглуулах, ярилцлага хийх, ослын акт үйлдэх, тэмдэглэл хөтлөх зэрэг ажлыг хариуцах төлөвлөгөө гарган ажиллана.

5.3. Өдөр тутмын аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгсөн эсэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтанд хамрагдсан байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт орсон зэргийг холбогдох баримтанд тулгуурлан судлан танилцана.

5.4. Осолдогч ажлын байрандаа шаардлагатай ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байсан эсэх, түүнийг заавар журмын дагуу хэрэглэж байсан эсэхийг судалж, ослын актад тусгана.

5.5. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байранд хөдөлмөрийн нөхцлийн болон эрсдэлийн үнэлгээг өмнө хийж байсан эсэх талаар судалж тогтооно.

5.6. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бүртгэх, судлан тогтооход шууд хамаарах тасаг, цех, бригад, нэгжийн ахлагч, инженер техникийн ажилтан, ажилтны болон Үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг комисст нэмж оролцуулж болно.

5.7. Осолдогчийн зан төлөв, ажлын туршлага, нас, хүйс, мэргэжил, боловсрол, төгссөн сургууль, ажилласан жил, амьдрал ахуйн талаар тодорхой мэдээлэл цуглуулна.

5.8. Осол, хурц хордлого гарсан ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн талаар тухайлбал, гэрэл, шуугиан доргион, тоос, халуун, хүйтэн, дотор, гадна, өндөрт ажиллаж байсан зэрэг мэдээлэл, баримтыг цуглуулж судална.

5.9. Осолдогч ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан, улирлын, түр ажлын байранд ажиллаж байсан, ээлжинд ажиллаж байсан, илүү цагаар ажилласан, цаг агаарын нөхцөл байдал ямар /бороотой, цастай, салхи шуургатай, хүйтэн, халуун өдөр/ байсан, ганцаараа болон хэдүүлээ ажиллаж байсан талаар мэдээлэл цуглуулж, судална.

5.10. Техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийнэ. Техник ашиглалтын паспорт хөтлөлт, урсгал болон хугацаат засвар үйлчилгээ хийгдэж байсныг үзэж, тогтооно.

5.11. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүтэц, тогтолцоо, дотоод хяналт, удирдах ажилтны талаас осолд нөлөөлсөн хүчин зүйл байсан эсэхийг судална.

5.12. Комисс нь зайлшгүй шаардлагатай бол ажил олгогчид мэдэгдэж, мэргэжлийн хяналт, эрүүл мэнд, хууль, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллагын дэмжлэг тусламж, үйлчилгээ авч болно.

### **Зургаа. Комиссын гишүүдийг сургаж, дадлагажуулах талаар**

6.1. Комиссын гишүүдийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтанд хамруулах, дадлага олгох, чадавхижуулах ажлыг ажил олгогч хариуцна.

6.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд судлан бүртгэх акт тогтоох мэдлэг, дадлагыг комиссын гишүүдэд эзэмшүүлэх талаар ажил олгогч тодорхой арга хэмжээ зохион байгуулна.

6.3. Комиссын гишүүдийг шаардлагатай ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр ажил олгогч хангасан байна.